



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/465

Улаанбаатар хот

“Орчны эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөөг
(2025-2028)” батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.2.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орчны эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г нэгдүгээр, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр)-д тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтийг ханган, шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөв, хамтын ажиллагаатай улс болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгахыг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газар (Л.Мөнхцэцэг)-т даалгасугай.
5. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 6 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний дотор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр)-д ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, нарт үүрэг болгосугай.

141252423

6. Төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайланг жил бүрийн 6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газарт ирүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр)-д үүрэг болгосугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028)

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын хөгжил дэвшлийн үндэс нь эрдэнэт хүн байх бөгөөд хүн эрүүл амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй, хүн амын эрүүл мэнд нь төрийн онцгой анхаарал, ивээлд байна гэж Үндсэн хуульд заасан билээ. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 5.3-т "хүн амын суурьшлын орчин, агаарын чанар, уур амьсгалын өөрчлөлт, ус хангамж, хог хаягдал, хөрсний бохирдлоос шалтгаалсан өвчин эмгэг, хордлогоос хүн амыг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулна", "Олон нийтийн оролцоо"-г хангах, Эрүүл мэндийн тухай хуулийн 43.2.4-т "хүний эрүүл мэнд болон нийгэмд аюул бүхий өвчин, хордлого, осол, гэмтэл, орчны сөрөг хүчин зүйлийн талаар эрүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь мэдээлэх" үүрэг хүлээхээр заасан байна.

Дэлхийн хүн амын өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, техник технологийн үсрэнгүй хөгжил дэвшил, улс орны бүтээн байгуулалттай холбоотойгоор хүрээлэн буй орчноос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэж байгаа бөгөөд ДЭМБ-ын судалгаагаар дэлхийн нийт нас баралтын 23 хувь буюу 12.6 сая хүн хүрээлэн буй орчны бохирдлоос хамаардаг болохыг тогтоожээ. Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх орчны хүчин зүйлийн тоо хэмжээг багасгаснаар, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулах, эрүүл мэндээ удаан хугацаанд хадгалах боломжтой болно.

Тогтвортой хөгжлийн зорилт 3.9-д 2030 он гэхэд аюултай химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол, халдвараас болж нас барсан, өвдсөн хүмүүсийн тоог үлэмж хэмжээгээр бууруулах зорилт тавьсан.

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5-ийн жилийн дундаж агууламж сүүлийн 10 жилд 2.5 дахин буурсан ч энэ нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 8 дахин их, үндэсний агаарын чанарын стандартаас 1.6 дахин их байна. (Эх сурвалж: НЭМҮТ, Орчны эрүүл мэндийн тандалтын тогтолцоо-2024 он, УБ хот 2025 он)

Монгол Улсад гадаад ба дотоод орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин 100,000 хүн амд 215 байгаа нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр байна. Тархины цус харвалт, зүрхний шигдээс өвчний шалтгаант нас баралтын 39% нь агаарын бохирдлоос шалтгаалж байна. (Эх сурвалж: ДЭМБ, 2024 он)

Монгол Улс 2022 онд хүн амын 39 хувь нь аюулгүй зохион байгуулагдсан ундны усны үйлчилгээгээр, 66.0 хувь нь аюулгүй зохион байгуулагдсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан байсан. Суулгалт өвчний шалтгаант нас баралтын 61.0 хувь нь шаардлага хангасан ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжгүй байдал, хувийн эрүүл ахуйн зохисгүй зан үйлээс шалтгаалдаг. (Эх сурвалж: JMP, 2023 он)

Монгол Улс нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг орнуудын нэг бөгөөд хэт халуун өдрийн тоо нэмэгдэх, ган гачиг, зудын давтамж нэмэгдэж байгаа нь

тархины харвалт, зүрхний өвчин, осол гэмтэл, уушгины өвчин гэх мэт байгаль орчны зүйлтэй холбоотой өвчлөлүүд нэмэгдэх, ган гачиг, үерээс шалтгаалан хачгаар дамжих халдвар, суулгалт өвчин нэмэгдэх хандлагатай байгаа.

Хоёр. Арга хэмжээний зорилго, зорилт

2.1. Монгол Улсын хүн амын эрүүл орчинд амьдарч, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, илрүүлэх, хянах, тандалтын тогтолцоог бэхжүүлэх, байгаль орчинд ээлтэй хөгжлийг дэмжихэд оршино.

2.2. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;

2.2.2. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг хангах;

2.2.3. Химийн бодисын аюулгүй хэрэглээг төлөвшүүлэх;

2.2.4. Уур амьсгалын өөрчлөлт ба эрүүл мэндийн чиглэлээр үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх;

2.2.5. Хот, суурин газрын дуу чимээ, гэрэлтүүлэг, барилгын орчны стандартыг хэрэгжүүлэх;

2.2.6. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа, нөлөөллийн үнэлгээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх.

Гурав. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

3.1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. Эрсдэлийн талаар бүрэн нотолгоо байхгүй ч хор хөнөөлийн боломж илэрсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.2. Монгол хүн бүр эрүүл орчинд амьдрах эрхтэй бөгөөд хүрээлэн буй орчны бохирдолд өндөр эрсдэлтэй, эмзэг бүлгийн хүн ам илүү их хамгаалалт авах ёстой;

3.1.3. Монгол хүн бүр хүрээлэн буй орчны бохирдол эрүүл мэндэд нь нөлөөлөх талаарх мэдээллийг чөлөөтэй, ойлгомжтой хэлбэрээр авах;

3.1.4. Төр, хувийн хэвшил, иргэний нийгэм болон иргэдийн идэвхтэй оролцоог хангаж, хамтын шийдвэр гаргалт, хариуцлагыг дэмжих;

3.1.5. Эрүүл мэнд, байгаль орчин, эрчим хүч, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл зэрэг холбогдох бүх салбарыг хамруулан нэгдсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа

4.1. Арга хэмжээг 2025-2028 онуудад хэрэгжүүлнэ.

4.2. Орчны эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөөг эрүүл мэнд, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт, батлан хамгаалах, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хууль зүй, боловсрол, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орчны эрүүл мэндийн чиглэлээр салбар дундын ажлын хэсгийг байгуулж ажиллуулна.

4.4. Ажлын хэсэг нь арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг жилд 2 удаа хэлэлцэж, хэрэгжилтийн явц, үр дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох мэргэжилтэнд танилцуулна.

4.5. Орчны эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага нь бусад төрийн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

Тав. Арга хэмжээний санхүүжилт

5.1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2 Засгийн газрын тусгай сангууд;

5.1.3. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.4. гадаадын зээл, буцалтгүй тусламж;

5.1.5. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

5.1.6. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Арга хэмжээний үр дүн.

6.1. Арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

6.1.1. Орчны эрүүл мэндийн бохирдлоос хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх тандалт, хяналт, нотолгоо сайжирна.

6.1.2. Зорилтот, эмзэг бүлгийн хүн амд орчны бохирдол, уур амьсгалын нөлөөллөөс өөрсдийгөө хамгаалах мэдээлэл, сурталчилгааг тэдний хэрэгцээнд нийцүүлэн хүргэх тогтолцоо бүрдэнэ;

6.1.3. Орчны эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийн 80-аас доошгүй хувийг чадавхжуулна.

6.1.4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагын 10-иас дээш хувь нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй эрүүл мэндийн байгууллага болох төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

6.1.5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хариу арга хэмжээ авах чадавх бэхжинэ.

6.1.6. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

6.1.6. Агаар, ус, хөрсний эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр мөрдөгдөж буй стандарт, журам, заавар, тушаалыг шинэчлэн боловсруулж, батлуулан, хэрэгжүүлнэ.



“ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД”
2025-2028 ОНД ХЭРЭГЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Эх үүсвэр	Нийт төсөв (сая төгрөг)	Суурь түвшин	Хүрэх түвшин, үр дүн, төсөв				Хэрэгжүүлэх байгууллага				Хэрэгжилтийг үнэлэх эх сурвалж
					2025 он		2026 он		2027 он		2028 он		
					Хүрэх түвшин	Төсөв (сая, төгрөг)	Хүрэх түвшин	Төсөв (сая, төгрөг)	Хүрэх түвшин	Төсөв (сая, төгрөг)	Хүрэх түвшин	Төсөв (сая, төгрөг)	

Зорилго: Монгол улсын хүн амын эрүүл орчинд амьдарч, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тандалтын тогтолцоог бэхжүүлэх, байгаль орчинд ээлтэй хөгжлийг дэмжихэд оршино.

Зорилт 1.Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Үйл ажиллагааны чиглэл 1. Агаарын чанарын хяналт, хэмжилтийн сүлжээг өргөжүүлэх

1.1.1	Дотоод орчны агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, стандарт батлуулах	-	-	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, 4585:2025	Батлагдсан MNS XXX:2025 стандарт	-	Стандартыг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	-	-	-	-	ЭМЯ НЭМҮТ	СХЗГ БЯ ХББӨСЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ	Батлагдсан дотоод орчны агаарын чанар стандарт	Батлагдсан
1.1.2	Дотоод орчны агаарын чанарыг хянах, тандах журам батлуулах	Улсын төсөв ОУБ	15,0	Тойм үнэлгээ	-	-	Батлагдсан журам	15,0	Журмыг холбогдох байгууллагад хүргүүлсэн албан тоот	-	Журмын хэрэгжилтийн тайлан	НЭМҮТ	ЭМЯ БЯ ХББӨСЯ	Батлагдсан журам	Батлагдсан
1.1.3	Орон нутгийн хүн амд агаарын чанарын индексээр мэдээлдэг тогтолцоог бий болгох	Улсын төсөв	20,0	УБ хотын мэдээлэл www.agaar.mn	-	-	Орон нутагт АЧИ-ээр Мэдээлэх нөхцөл байдлын тайлан	20,0	-	-	АЧИ-ээр хүн амд мэдээлэл хүргэдэг аймгийн тоо- 21	ЭМЯ БОУАӨЯ ЦУОШГ	НЭМҮТ Аймгийн ЦУОША Холбогдох Төрийн болон ТББ	21 аймгийн төвийн хүн амд АЧИ-ээр мэдээлэл хүргэдэг цахим сайт	21 аймгийн

Үйл ажиллагааны чиглэл 2. Ноголгоонд суурилсан бодлогоор хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах

1.2.1	Агаарын бохирдлын эх үүсвэр, тархалт, улирлын хэлбэлзэл, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийх	Улсын төсөв, ОУБ	100,0	Хот, аймгийн төвд жил бүр агаар бохирдуулагчийн тооллого	-	-	Агаарын бохирдлын эх үүсвэр, тархалт, улирлын хэлбэлзэлийн тайлан, Аймаг, нийслэлийн тоо 21	25,0	Агаарын бохирдол, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний тайлан, Аймаг, нийслэлийн тоо 21	25,0	Туршлага солилцох уулзалт	50,0	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ	ЭМЯ, НЭМҮТ, ЦУОШГ	21 аймгийн үнэлгээний тайлан, шийдвэр Туршлага солилцох уулзалтаас гарсан зөвлөмж, саналыг хүргүүлсэн албан бичиг
-------	---	------------------	-------	--	---	---	---	------	---	------	---------------------------	------	-----------------------------	-------------------	---

1.2.2	Сургуулийн дотоод орчны агаарын чанарыг үнэлэх	"Эрүүл монгол хүн" хөдөлгөөн	70,0	2022 оны үнэлгээний тайлан	Үнэлгээний арга зүйг баталсан ЭЗХ, АУЕЗХХ-ны тогтоол	-	Сургуулийн дотоод орчны агаарын чанар үнэлгээний тайлан, Үнэлгээний үр дүнг олон нийтэд түгээсэн тайлан	70,0	-	-	-	-	НЭМҮТ	БЯ ШУТИС	Үнэлгээний тайлан
1.2.3	Дотоод орчны агаарын чанарын эрүүл мэндэд үзүүлэх үнэлгээ хийх	Улсын төсөв, ОУБ	100,0	2022 оны судалгааны тайлан	-	-	Дотоод орчны агаарын чанарын үнэлгээ	50,0	25,0	Дотоод орчны агаарын чанарын үнэлгээ	25,0	НЭМҮТ АШУУИС	ЭМЯ, НЭДТГ, холбогдох Төрийн болон ТББ	Үнэлгээний тайлан	
1.2.4	Агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, урьдчилан сэргийлэх талаар үндэсний салбар дундын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Улсын төсөв, ДЭМБ, НҮБХС	300,0	2024 оны салбар дундын хэлэлцүүлэг	-	-	Уулзалт, хэлэлцүүлэг	150,0	-	Уулзалт, хэлэлцүүлэг	150,0	ЭМЯ	НЭМҮТ, АШУУИС	Уулзалт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж	
Үйл ажиллагааны чиглэл 3. Агаарын бохирдолд өндөр өртөх эрсдэлтэй эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх, хамгаалах нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах															
1.3.1	Агаарын бохирдолтой үед жирэмсэн эмэгтэйчүүд, 0-5 насны хүүхэд, өндөр настан, амьсгал, зүрх судасны өвчтэй хүмүүсийг агаарын бохирдолтой холбоотой эрсдэлийн үнэлгээ хийх	Улсын төсөв	50,0	Монгол улсын шадар Сайдын 28 дугаар тушаал	-	-	Эрсдэл гарсан тохиолдол бүрд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	20,0	15,0	Эрсдэл гарсан тохиолдол бүрд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	15,0	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЗДТГ	НЭМҮТ	Эрсдэлийн үнэлгээ хийж авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан	
1.3.2	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилчдыг агаарын бохирдолд эмзэг, өртөмхий бүлгийг хамгаалах, сэргийлэх үйл ажиллагааг хэвшүүлэх	Улсын төсөв, ОУБ	100,0	ЭМЯ, НҮБХС, НЭМҮТ, Эмч, эмнэлгийн ажилчдад зориулсан зөвлөмж, 2023 он	-	-	Анхан шатны ЭМБ-ын 80 ажилчдыг чадавхжуулах, Эмзэг, өртөмхий бүлэгт чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн аймгийн тоо-10	60,0	20,0	Эмзэг, өртөмхий бүлэгт чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн аймгийн тоо-21	20,0	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЗДТГ	ЭМЯ, НЭМҮТ	НЭМҮТ Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан	

1.3.3	Сургууль, цэцэрлэг, олон нийтийн газар зэрэг байгууллагдах дотоод орчны агаарын чанарыг сайжруулах технологийг үе шаттай хэрэгжүүлэх	Улсын төсөв, ОУБ Бусад эх үүсвэр	200,0	Сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанар, судалгаа, 2023 он	-	Дотоод орчны агаарын чанарыг сайжруулах удирдамж	100,0	Дотоод орчны агаарын чанарыг сайжруулах технологи нэвтрүүлсэн байгууллага-10	50,0	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЗДТГ	ЭМЯ, БЯ, НЭМҮТ	НЭМҮТ Дотоод орчны агаарын чанарыг сайжруулах технологи нэвтрүүлсэн тайлан
-------	--	-------------------------------------	-------	---	---	--	-------	--	------	-----------------------------	----------------	---

Зорилт 2. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг хангах

Үйл ажиллагааны чиглэл 2.1. Ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах, чанарын хяналтыг сайжруулах

2.1.1	"Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар"-ыг шинэчлэх	Улсын төсөв, ДЭМБ	15,0	ЭМС, БХБС-ын 2017 оны А/149/78 дугаар хамтарсан тушаал	-	Ажлын хэсгийн тушаал, Шинэчлэн батлагдсан тушаал	15,0	Үнэлгээ хийсэн байгууллага-10	-	Хэрэгжилтийн тайлан	ЭМЯ, ХББООЯ	НЭМҮТ БОУАӨЯ АШУУИС ОБЕГ, БХТ, ХСУХАТА УЗХ, УСҮГ	Шинэчлэн батлагдсан тушаал, заавар, хэрэгжилтийн тайлан
2.1.2	Нүхэн жорлон. Угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартыг шинэчлэх	Улсын төсөв, ОУБ	15,0	MNS 5924:2015 стандарт	-	Ажлын хэсгийн тушаал, Шинэчлэн батлагдсан стандарт	15,0	Стандартыг хүн амд сурталчилсан тайлан	-	ЭМЯ	СХЗГ, Аймаг, нийслэлийн ЭМГ, холбогдох байгууллагууд	Шинэчлэн батлагдсан стандарт, сурталчилсан тайлан	
2.1.3	Эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг үнэлэх, сайжруулах заавар боловсруулах	Улсын төсөв, ОУБ	50,0	ЭМБ-ын үнэлгээний тайлан, сургалт 2022-2024 он	Үндэсний хэмжээнд бэлтгэгдсэн сурлагч багш, n=80	Ажлын хэсгийн тушаал, батлагдсан заавар	50,0	Батлагдсан зааврыг хэрэгжүүлсэн ЭМБ-ын тоо-10	-	Батлагдсан зааврыг хэрэгжүүлсэн ЭМБ-ын тоо-20	ЭМЯ, НЭМҮТ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, бусад холбогдох байгууллагууд	Батлагдсан удирдамж, ЭМБ-ын УАЦАА-г сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан
2.1.4	Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага, стандартыг шинэчлэх	Улсын төсөв, ДЭМБ	15,0	MNS 6392:2013 стандарт	-	Ажлын хэсгийн тушаал, Шинэчлэн батлагдсан стандартын төсөл	15,0	Шинэчлэн батлагдсан стандарт	-	ЭМЯ, СХЗГ	Холбогдох байгууллагууд	Батлагдсан стандарт	
2.1.5	ЭМБ-ын хог хаягдлын менежментэд зарцуулагдах төсөв, зардлыг тооцох аргачлалыг шинэчлэх	Улсын төсөв	15,0	ЭМС-ын 2019 оны 605 дугаар тушаал	-	Ажлын хэсгийн тушаал, Шинэчлэн батлагдсан тушаал	15,0	Төсөв, зардал тооцох цахим сургалтын тоо-2	-	ХӨСҮТ	ЭМЯ	Батлагдсан аргачлал	

ЭМБ-ын аюултай хог хаягдлын ажилтныг мэргэжлийн индексгүй болгох, мэргэжлүүлэх сургалтаар хог хаягдлын ажилтан бэлтгэх		Улсын төсөв	100,0	-	-	-	Ажлын хэсгийн тушаал, Ажлын байрны нөхцөлийг үнэлэх, ажлын байрны тодорхойлолт	-	Батлагдсан мэргэжлийн индекс	20,0	Мэргэшүүлэх сургалтын тоо-1	80,0	ХӨСҮТ ЭМХТ	ГБХНХЯ ЭМЯ	Ажлын байрны нөхцөлийг үнэлэх, ажлын байрны тодорхойлолт, батлагдсан мэргэжлийн индекс
Үйл ажиллагааны чиглэл 2.2. Хүн амын ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, хүчин чадлыг дээшлүүлэх															
2.2.1	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хөрс, усны бохирдлын эрүүл мэндийн эрсдэлийг тогтоох	Улсын төсөв	15,0	-	МУ-ын шадар Сайдын 2023 оны 28 тоот тушаал	-	Эрсдэлийн үнэлгээний тайлан	5,0	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн удирдамж боловсруулж, батлуулах	5,0	Удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах	5,0	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЗДТГ	ЭМЯ НЭМҮТ Холбогдох байгууллагууд	Эрсдэлийг үнэлж авч хэрэгжүүлсэн ажлын тайлан
2.2.2	Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүлэмжийн хийн ялгарлыг сонгон авсан эрүүл мэндийн байгууллага, өрхийн түвшинд тооцох	Улсын төсөв, НҮБ-ын Хүүхдийн сан	150,0	-	20 байгууллага, 20 өрх	150,0	-	-	-	-	Хүлэмжийн хийн ялгарал тооцсон байгууллага, өрхийн тоо: 40	-	ЭМЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан, ШУТИС	БОУАЭЯ НЭМҮТ АШУИС	Тайлан
2.2.3	Хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд эрүүл ахуйн хяналт, үнэлгээ хийх	Улсын төсөв, ДЭМБ, НҮБХС	60,0	-	Хяналт үнэлгээний тайлан	Хяналт шалгалтын тайлан	Хяналт үнэлгээний тайлан	20,0	Хяналт үнэлгээний тайлан	20,0	Хяналт үнэлгээний тайлан	20,0	ЭМЯ, НЭМҮТ	БОУАЭЯ Бүх шатны Засаг дарга, Аймаг, нийслэлийн ЭМГ	Жил бүрийн хяналт, үнэлгээний тайлан
2.2.4	Хот, суурин газрын суурьшлын бүсийн хөрсний бохирдлын байдалд хяналт шинжилгээ хийх	Улсын төсөв,	60,0	-	Хяналт үнэлгээний тайлан	Хяналт шалгалтын тайлан	Хяналт үнэлгээний тайлан	20,0	Хяналт үнэлгээний тайлан	20,0	Хяналт үнэлгээний тайлан	20,0	ЭМЯ НЭМҮТ	БОУАЭЯ Бүх шатны Засаг дарга, Аймаг, нийслэлийн ЭМГ	Жил бүрийн хяналт, үнэлгээний тайлан
2.2.5	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинд хяналт үнэлгээ хийх	Улсын төсөв	30,0	-	Хяналт үнэлгээний тайлан	Хяналт шалгалтын тайлан	Хяналт үнэлгээний тайлан	10,0	Хяналт үнэлгээний тайлан	10,0	Хяналт үнэлгээний тайлан	10,0	ЭМЯ НЭМҮТ	ХБЕОСЯ, НЭМҮТ, НЭМГ, Аймгийн ЭМГ	Жил бүрийн хяналт, үнэлгээний тайлан

2.2.6	Эрүүл мэндийн байгууллага, олон нийтийн үйлчилгээний газар дахь гарын ариун цэвэр сахих нөхцөлийг үнэлж, эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай савангийн зардлыг нэмэгдүүлэх зөвлөмж хүргүүлэх	Улсын төсөв НҮБХС	97,0	ЭМБ дахь гарын эрүүл ахуй сахих нөхцөлийн үнэлгээний тайлан, 2024	-	-	-	Нийт 3 аймаг, сум, УБ хотын нийт 20 ЭМБ, 16 олон нийтийн байгууллагын үнэлгээний урьдчилсан дүн, зөвлөмж, санал хүргүүлэх	97,0	Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх	-	-	-	НЭМҮТ Аймаг, нийслэлийн н ЭМГ	ЭМЯ, Холбогдох Төрийн болон ТББ	Үнэлгээний тайлан, нөлөөллийн аян зохион байгуулсан тайлан
2.2.7	Нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууллагаар үе шаттай солих дэмжлэгийн хөтөлбөр хэрэгжүүлэх	Улсын төсөв	500,0	Эрүүл ахуйн аян, 2023-2024 он	-	-	-	Шинэчлэгдсэн ариун цэврийн байгууламжийн тоо 5	100,0	Шинэчлэгдсэн ариун цэврийн байгууламжийн тоо 10	200,0	Шинэчлэгдсэн ариун цэврийн байгууламжийн тоо 15	300,0	Аймаг, нийслэлийн н ЗДТГ, ЭМГ	ЭМЯ, БОУАӨЯ, БЯ	Хөтөлбөр хэрэгжилтийн үр нөлөө, Шинэчлэгдсэн ариун цэврийн байгууламжийн тоо 30
2.2.8	Эрүүл мэндийн байгууллагуудад ханган нийлүүлсэн аюултай хог хаягдал боловсруулах, устгах тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд хяналт, үнэлгээ хийх	Улсын төсөв	50,0	ЭМС-ын 2023 оны А/357 дугаар тушаал	-	-	-	Үнэлгээний тайлан, хяналт 100%	50,0	Санал, зөвлөмжийн дагуух ашиглалтын хувь	-	-	-	ЭМЯ, ХӨСҮТ	БОУАӨЯ	Үнэлгээний тайлан, тоног төхөөрөмжийн ашиглалт
2.2.9	ЭМБ-аас үүсч байгаа хог хаягдлыг дахин боловсруулах, хоёрдогч түүхий эдээр ашиглах боломж нөхцөлийн судалгаа хийх	Улсын төсөв	30,0	ЭМС-ын 2025 оны А/173 дугаар тушаал	-	-	-	Судалгааны тайлан	20,0	Хог хаягдлын дахин боловсруулалтыг турших, ЭМБ-2	10,0	Хог хаягдлын дахин боловсруулалтыг туршсан тайлан, зөвлөмж	-	ЭМЯ, ХӨСҮТ	БОУАӨЯ	Судалгаа, туршилтын тайлан
2.2.10	ЭМБ-аас үүсч байгаа аюултай хог хаягдал, түүний устгал, боловсруулалт хийхэд байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдалд ЭМНУ хийх	Улсын төсөв	120,0	-	-	-	-	Байгаль орчин, ЭМНУ хийхэд шаардагдах зардал	80,0	Зардал шийдэгдсэн ЭМБ-ын байгаль орчин, ЭМНУ-ний тайлан	40,0	-	-	ЭМЯ, ХӨСҮТ	БОУАӨЯ, НЭМҮТ, Холбогдох ЭМБ	ЭМНУ-ний тайлан
2.2.11	Эрүүл мэндийн байгууллагаас үүсч байгаа аюултай хог хаягдлыг мэдээллийн платформд холбох	Улсын төсөв	100,0	ЭМС-ын 2025 оны 193-р тушаал	-	-	-	Ажлын Хэсгийн тушаал	20,0	Цахим програм, платформ	80,0	Эргэн мэдээлэл	-	ЭМЯ, ХӨСҮТ, ЭМХТ	ЦХИХХЯ, БОУАӨЯ	Аюултай хог хаягдлын мэдээллийн платформ

Үйл ажиллагаа 2.3 Үндэсний усны чанар, аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламж, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн тогтвортой байдлыг хангах, бохирдлыг бууруулах, өртөлтөөс хамгаалахад чиглэсэн ухуулга, нөлөөллийн арга хэмжээ

2.3.1	Ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг дэмжих чиглэлээр үндэсний сургалт зохион байгуулах	Улсын төсөв, ОУБ	200,0	Сургалтын тайлан	-	-	-	-	Үндэсний, орон нутгийн бэлтгэгдсэн 30 сургагч багш	50,0	Бүсчилсэн талбарын сургалт-5	150,0	ЭМЯ, ХБӨСЯ, ХСҮХАТА ҮЗ, МОХЭМН	Холбогдох байгууллагууд	Сургалтын тайлан, төлөвлөгөө хэрэгжүүлж буй аймаг
2.3.2	Ус хангамж, ариун цэврийн байгууламжид тавих хяналтын талаар улсын байцаагчдад зориулсан сургалт зохион байгуулах	ДЭМБ	30,0	-	-	-	-	-	Улсын байцаагчдад зориулсан сургалт	30,0	-	-	ЭМЯ, ХБӨСЯ, НЭМҮТ	Холбогдох байгууллагууд	ЭМЯ-ны Хяналт, шинжилгээний тайлан
2.3.3	Гар угаах, ундны усны бохирдлоос сэргийлэх дадлыг нэмэгдүүлэх зорилготой үндэсний хэмжээний компани ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	30,0	Эрүүл ахуйн аян, 2023-2024 он	-	Компани ажлын уриа, зорилго, зорилготой бүлэг, суурь үзүүлэлт	15,0	Компани ажил	10,0	Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг танилцуулах	5,0	Аймаг, нийслэлийн НЭМГ	ЭМЯ, БЯ, НЭМҮТ	Компани ажлын тайлан, аймаг, нийслэл n=22	
2.3.4	Шаардлага хангаагүй ус, ариун цэврийн байгууламж болон эрүүл ахуйн дадалтай холбоотой суулгалт өвчний тархалтыг судлах	Улсын төсөв	200,0	Гэдэсний халдварт өвчний тандалт ЭМХТ, 2024	-	-	-	-	Судалгааны батлагдсан арга зүй, ёс зүйн тогтоол, судалгааны тайлан, зөвлөмж	200,0	Зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх	-	НЭМҮТ ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	Судалгааны тайлан

Зорилт 3. Химийн бодисын аюулгүй хэрэглээг төлөвшүүлэх

Үйл ажиллагааны чиглэл 3.1. Химийн бодисын бүртгэл, тандалтын тогтолцоог бэхжүүлэх

3.1.1	Эрүүл мэндийн Сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 427 дугаар тушаалаар батлагдсан "Химийн бодисын хордлогыг тандах, мэдээлэх журам"-ыг шинэчлэн батлуулах (захиргааны хэм хэмжээний акт бүртгүүлэх)	Улсын төсөв	15,0	Эрүүл мэндийн Сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 427 дугаар тушаал	Мэдээллийн сан, мэдээллийн цахим тандалтын систем	Батлагдсан журам	15,0	Журам танилцуулах сургалт, журмын хэрэгжилтийн тайлан	-	Журмын хэрэгжилтийн тайлан	-	ЭМЯ, НЭМҮТ, ЭМХТ	Салбар хоорондын байгууллага	Сайдын батлагдсан тушаал
-------	--	-------------	------	--	---	------------------	------	---	---	----------------------------	---	------------------	------------------------------	--------------------------

3.1.2	ДЭМБ-ын Химийн эрсдэлийн үнэлгээний сүлжээ, INTOX зэрэг бүс нутгийн болон олон улсын химийн хордлогын сүлжээний үйл ажиллагаанд тэргүүлэх ач холбогдол өгч элсэн орох, хамтран ажиллах	Улсын төсөв ДЭМБ	10,0	INTOX сүлжээнд элсэн ороогүй.	-	-	-	ДЭМБ-ын Химийн эрсдэлийн үнэлгээний сүлжээ INTOX сүлжээнд элсэн орох суурь түвшинг бүрдүүлэх арга хэмжээ, хэрэгжилтийн хувь	10,0	Олон улсын хими болон химийн сүлжээнд элссэн баримт бичиг	-	INTOX-ийн мэдээллийн сан, арга зүй, стандарт тайлангийн загвар ашиглан хордлогын тохиолдлыг үнэлэх, ангилах, хариу арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилт	ЭМЯ, НЭМҮТ	БОУАӨЯ, ОБЕГ	INTOX сүлжээнд элсэн орсон нотлох баримт бичиг
3.1.3	"Хар тугалгагүй ирээдүйн төлөөх түншлэл" -д нэгдэх	Улсын төсөв НҮБХС, ДЭМБ	200,0	2025 оны 4-р сарын 25-ны өдөр. Хүүхдийн ОЗМ-ийн хамтын ажиллагаанд ЭМЯ-наас нэгдсэн.	Цусан дахь хар тугалганы хэмжээг тодорхойлох үндэсний судалгааг эхлүүлэх	150,0	Нотолгоонд суурилсан тэргүүлэх чиглэл	10,0	Батлагдсан бодлогын баримт бичиг	10,0	Чадавхи бүрдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	30,0	ЭМЯ	Холбогдох төр, хувийн хэвшлийн байгууллагууд	Үндэсний судалгааны тайлан, тэргүүлэх чиглэл, холбогдох бодлогын баримт бичиг
Үйл ажиллагааны чиглэл 3.2. Орон сууц, сургууль, цэцэрлэг, ажлын байрны орчинд химийн бодисын өртөлтийг бууруулах															
3.2.1	Хүүхэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн "Химийн бодисын эрсдэлгүй ирээдүй" сэдэвт мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	85,0	-	ДЭМБ-аас анхааруулсан аюултай, хортой 10 химийн бодисын чиглэлээр сургалтын агуулга, материал боловсруулах, төлөвлөгөө хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөөг танилцуулж, хэрэгжүүлэх, химийн бодисын эрсдэл, хор хөнөөлийн талаарх суурь ойлголтыг бэхжүүлэх, үе тэнгийн сургалч багш-100	30,0	Сургуулийн орчинд химийн аюулгүй байдлын соёл төлөвшүүлэх, үе тэнгийн сургалч багш нараар дамжуулан сургалт явуулах, хэрэгжилтийн хувь 50	20,0	Сургуулийн орчинд химийн аюулгүй байдлын соёл төлөвшүүлэх, үе тэнгийн сургалч багш нараар дамжуулан сургалт явуулах, хэрэгжилтийн хувь 100	35,0	БЯ, ЭМЯ, НЭМҮТ	Салбар хоорондын байгууллага	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь
3.2.2	Угаарын хийн хордлогоос сэргийлэх, өртөлтийг бууруулах чиглэлээр нийт иргэд болон зорилтот бүлгийнхэнд мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх	Улсын төсөв	100,0	2024 онд 23 удаагийн ярилцлага, лайв, 8 сэдвийн хүрээнд 295 инфографик, 9 видео шторк	30 төрлийн контент, улирал бүр мэдээлэл сурталчилгааны аян	-	30 төрлийн контент, хичээлийн, улирал бүр мэдээлэл сурталчилгааны аян	40,0	30 төрлийн контент, аян	30,0	30 төрлийн контент, аян	30,0	НЭМҮТ, ЭМЯ	АБҮХ-ны ажлын алба, Салбар хоорондын байгууллага	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь

3.2.3	Айл өрхийн түвшинд ахуйн хэрэглээнд (халаалт, хоол хийх болон бусад зорилгоор) ашиглаж буй газрын аюулгүй хэрэглээг хангах, болзошгүй осол, дэлбэрэлтээс сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх	Улсын төсөв	60,0	2024 онд ахуйн газрыг хордлогоос сэргийлэх 3D инфографик, 3 видео шторк	10 төрлийн контент	-	10 төрлийн контент	20,0	10 төрлийн контент	20,0	ЭМЯ, БХЯ, АУЗБЯ, НЗМУТ	Салбар хоорондын байгууллага	Боловсруулсан завар, сурталчилгааны тайлан
Үйл ажиллагааны чиглэл 3.3. Ауултай химийн бодистой ажиллагчдын хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх													
3.3.1	Болзошгүй гамшиг, химийн ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг үнэлэх, зураглал боловсруулах, эрсдлийг бууруулах	Улсын төсөв	60,0	Стандартын шаардлага хангасан агуулах 35% мэдээллийн нэгдсэн бүртгэлтэй 40%	Нийслэлийн хэмжээнд шатахуун түгээх станцын эрсдэлийн үнэлгээний тайлан	-	Нийслэлийн хэмжээнд эрсдэл тооцоолох, зураглал	30,0	Эрсдэл өндөртэй 3 аймаг ослын зураглал гаргах	20,0	Эрдсийн үнэлгээний тайлан, Сургалтын тайлан	ЭМЯ ОБЕГ БОУАӨЯ	Эрсдэл хүчин зүйлийг арилгах төлөвлөгөөний биелэлт
3.3.2	Монгол улсын хөдөлмөрийн эрүүл мэндийн төлөв байдлыг шинэчлэх, нийтийн хүртээл болгох	ДЭМБ	10,0	МУ-н хөдөлмөрийн эрүүл мэндийн эмхэтгэл 2019	Хөдөлмөрийн эрүүл мэндийн төлөв байдал (2020-2024) эмхэтгэлийн төсөл	-	Хөдөлмөрийн эрүүл мэндийн төлөв байдал (2020-2024) эмхэтгэл	10,0	-	-	ГБХНХЯ, ХАБЭМТ, АШУУИС-ийн НЗМС	ЭМЯ ТББ, мэргэжлийн холбоод	Хөдөлмөрийн эрүүл мэндийн төлөв байдал (2020-2024) хэвлэгдсэн эмхэтгэл
3.3.3	Ажил хөдөлмөртэй холбоотой өвчлөлийн ачааллыг тооцох олсон улсын шинэ үзүүлэлтийг нутагшуулах	ДЭМБ	10,0	Шинэ шалгуур үзүүлэлтийн тоо	ҮОМШӨ-ний бүртгэл статистик мэдээллийн сан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт	10,0	ХАБЭМ-н үндсэн үзүүлэлтийн дагуу мэдээлэл солилцох	-	ГБХНХЯ, ХАБЭМТ	ЭМЯ ЭМХТ	Ажил хөдөлмөртэй холбоотой өвчлөлийн ачааллыг тооцох шалгуур үзүүлэлт
3.3.4	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын ажлын байрны аюулгүй байдал, эрсдлийг үнэлэх аргаачлалыг боловсруулах, батлуулах	Улсын төсөв	30,0	Аргаачлалын төсөл	-	-	Ажлын хэсгийн тушаал, Батлагдсан аргаачлал	10,0	-	-	Хэрэгжилтийн үнэлгээ	ГБХНХЯ, ХАБЭМТ	Батлагдсан аргаачлал, хэрэгжилтийн үнэлгээ
Зорилт 4. Уур амьсгалын өөрчлөлт ба эрүүл мэндийн чиглэлээр үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх													
4.1. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хүрээлэн буй орчинд ээлтэй эрүүл мэндийн байгууллага													

[illegible]

4.2.1	Хүн амын дунд УАӨ-ийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, өвчлөлийн үндэсний хэмжээний судалгаа (халдварт, халдварт бус) хийх	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр	300,0	3	www.tandalt.mn п. www.1313.mn	-	Судалгааны чиглэл	-	Судалгааны батлагдсан арга зүй ЗЗХ, АУЕЗХХ-ны тогтоол	100,0	Шинэчлэгдсэн тандалт, мэдээллийн систем	Судалгааны тайлан, судалгааны үр дүнг түгээх	300,0	-	ЭМЯ, НЭМҮТ	МАУА	Шинээр хийгдсэн судалгааны тайлан
4.2.2	УАӨ-өөс шалтгаалсан өвчлөлийн талаарх тоо, баримт, нотолгоог нэмэгдүүлж, тандалт, мэдээллийн болон эрт сэрэмжлүүлэх системийг хөгжүүлэх (статистик тооцоолол, тандалт хийх, эрт сэрэмжлүүлэг хийх тандалтын чадавхыг сайжруулах)	Улсын төсөв, ДЭМБ, НҮБХХ	350,0			-	Одоогийн тандалтын чадавхын үнэлгээ	100,0	Шинэчлэгдсэн тандалт, мэдээллийн систем	250,0	Эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бүрэн ажиллагаанд оруулах	ЭМЯ, ЗӨСҮТ	НЭМҮТ, ЗӨСҮТ, ОБЕГ, ЦУОШГ	Хөгжүүлсэн системийн тоо, шинэчлэлтийн давтамж, сэрэмжлүүлгийн мэдээний тоо			
4.2.3	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчин, зоонозын шалтгаант НЭМ-ийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээг сайжруулах	Улсын төсөв, олон улсын байгууллага	500,0	-	Зоонозын шалтгаант өвчний дэгдэлтийн үеийн ЭХХОНО-ны чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа, Хангайн бүсийн 3 аймагт	-	ЭХХОНО-ны чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа, Төвийн бүсийн аймгууд	200,0	Анхан шатны ЭМБ-ын 100 эмч нарыг чадавхижуулах,	100,0	Анхан шатны ЭМБ-ын 200 эмч нарыг чадавхижуулах	ЭМЯ, ЗӨСҮТ	Аймаг нийслэлийн ЭМГ, БОУАӨЯ, ОБЕГ	ЗӨСҮТ-ийн тайлан			
4.3. Ухуулга, нөлөөлөл, мэдээлэл, сургалт, сурталчилгаа																	
4.3.1	*Уур амьсгалын өөрчлөлийн нөлөөллийг бууруулах дасан зохицох талаар олон нийт, зорилгот бүлэгт зориулсан нотолгоонд тулгуурласан зөвлөмж, мэдээлэл, сурталчилгааны багц боловсруулж, түгээх	Улсын төсөв, олон улсын төсөл, хөтөлбөр	150,0	-		-	Мэдээлэл, сурталчилгааны багц	50,0	Олон нийтэд түгээж, жил бүр хүрэлцээ, нөлөөллийн үнэлгээний тайлан	100,0	Олон нийтэд түгээж, жил бүр хүрэлцээ, нөлөөллийн үнэлгээний тайлан	ЭМЯ	НЭМҮТ, Аймаг нийслэлийн ЭМГ, Боловсролын газар	Мэдээлэл, ухуулгын багц, сурталчилгааны тайлан, үнэлгээ			
4.3.2	Уур амьсгалын өөрчлөлт ба эрүүл мэнд үндэсний хэмжээний чуулган зохион байгуулах	Улсын төсөв, ОУБ	250,0	-		-	Үндэсний чуулган зохион байгуулах, Бодлогын зөвлөмж, санал дүгнэлт	250,0	-	-	-	ЭМЯ, БОУАӨЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Чуулганы тайлан, гарсан зөвлөмж, шийдвэрийн баримт бичиг			

5.1.1	Дуу шуугианы эх үүсвэр, тархалтын суурь үнэлгээ хийх	Улсын төсөв	150,0	УБ хотын автотээврийн чимээ, судалгаа, 2024	-	-	Хүрээлэн буй орчны дуу шуугианы хэмжээний тайлан	150,0	Дуу шуугианы бүс	-	Дуу шуугианы эх үүсвэр, тархалтын суурь үнэлгээ хийх зөвлөмж	ЭМЯ, НЭМҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ХБЕОСЯ, ТЦА	Дуу шуугианы суурь үнэлгээний тайлан
5.1.2	Суурьшлын орчны дуу, шуугианы стандартыг шинэчлэн боловруулах	Улсын төсөв	10,0	Дуу шуугианы стандарт MNS 0012-1-009:1985	-	-	-	-	Ажлын хэсгийн тушаал, Батлагдсан стандарт	10,0	Стандартыг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	-	НЭМҮТ	Батлагдсан стандарт
5.1.3	Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвүүдийг оролцуулсан эмзэг бүтцийн эрсдэлийн үнэлгээ хийх	Улсын төсөв	400,0	-	-	-	Үнэлгээний арга зүй боловсруулж эрдмийн зөвлөл, АУЕЗХХ-гоор батлуулсан тогтоол	20,0	Үнэлгээний тайлан	380,0	Үнэлгээний үр дүнг шийдвэр гаргагчдад хүргэх	ЭМЯ, БЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	ЭМЯ, БЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	Үнэлгээний тайлан
Зорилт 6. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа, нөлөөллийн үнэлгээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх														
6.1	Хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тандах "GEO-HEALTH LAB" өргөжүүлэх	НҮБХС	256,0	Агаар, хөрс, усны бохирдлын зарим үзүүлэлт	Батлагдсан удирдамж	-	Сургалт, n=30	-	"GEO-HEALTH LAB"	30,0	Хүрээлэн буй орчны бохирдлын үзүүлэлт	НЭМҮТ	НБСШТ Холбогдох ТББ	Байгуулагдсан "GEO-HEALTH LAB"
6.2	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний эрх зүйн баримт бичгийг шинэчлэн боловсруулах	Улсын төсөв	30,0	ЭМС-ын 2023 оны А/142, А/169, А/350 дугаар тушаалууд	-	-	Шинэчлэгдсэн журмууд	30,0	Журмын хэрэгжилтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах	-	Журмын дагуу хэрэгжүүлсэн нөлөөллийн үнэлгээ	ЭМЯ	БОУАЭЯ НЭМҮТ ТББ	Батлагдсан журам
6.3	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний чиглэлээр ажилладаг хүний нөөцийг бэлтгэх	Улсын төсөв ОУБ ДЭМБ	100,0	10	-	-	20	20,0	30	30,0	40	ЭМЯ НЭМҮТ АШУУИС	Холбогдох байгууллагууд	Сургалсан мэргэжилтний тоо
6.4	Орчны эрүүл мэндийн чиглэлээр хийгдсэн тогтмол үнэлгээ, кодчилсон мэдээллийн сан үүсгэх	ДЭМБ	100,0	Агаарын чанар эрүүл мэндийн тойм үнэлгээ, кодчиллол	Холбогдох судалгаа, үнэлгээг цуглуулж кодлох	40,0	Цахим платформд оруулах	40,0	Цахим платформын ашиглалт	20,0	Цахим платформын ашиглалт	ЭМЯ АШУУИС	ЭМЯ	Цахим платформ
6.5	Хүрээлэн буй орчин – Эрүүл мэндийн салбар дундын хамтарсан ажлын хэсгийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Улсын төсөв ОУБ	30,0	ЭМС, БОАЖС-ын 2023 оны А/482, А/657 тоот тушаал	Шинэчилсэн ажлын хэсгийн тушаалын төсөл	-	Шинэчилсэн ажлын хэсгийн тушаал, Ажиллах журам, Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо-4	10,0	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо-4	10,0	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо-4	ЭМЯ, БОУАЭЯ	НЭМҮТ, ХӨСҮТ	Шинэчилсэн тушаал Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тушаал



Эрүүл мэндийн сайдын 2025 оны
10-ны дугаар сарын 10-ны
өдрийн 08.10.25 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ /2025-2028/-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин				Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
			түвшин	он	2025 он	2026 он	2027 он	2028 он		
Нэг. Үр нөлөөний шалгуур үзүүлэлт										
1.	25-аас дээш насны хүн амын уушгины хавдрын шалтгаант нас баралт	Тухайн насны 100,000 хүн амд	26.9	2024	25.7	24.7	24.2	23.7	Жил бүр	ЭМХТ
2.	25-аас дээш насны хүн амын зүрхний ишеми өвчний шалтгаант нас баралт	Тухайн насны 100,000 хүн амд	126.8	2024	123.8	117.8	110.8	105.8	Жил бүр	ЭМХТ
3.	5 хүртэлх насны суулгалт өвчин	10,000 хүүхдэд	512.7	2024	477.5	447.0	420.5	380.0	Жил бүр	ЭМХТ
4.	Санамсаргүйгээр хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралт (Х40-49)	100,000 хүнд	33.3	2024	33.0	32.7	32.1	31.0	Жил бүр	ЭМХТ
Хоёр. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт										
1.	Орчны эрүүл мэндийн чиглэлээр чадавхжсан мэргэжилтэн	Хувь	30.0	2024	30.0	35.0	35.0	80.0	Жил бүр	ЭМЯ
2.	Орчны эрүүл мэндийн тандалт, хяналтыг сайжруулах зорилгоор баталсан стандарт, журам, аргачлал	Тоо	1	2024	2	3	1	1	Жил бүр	ЭМЯ
3.	Туршилтаар усны эх үүсвэрт нь гэдэсний савханцар (E.Coli) илэрсэн өрхөд амьдардаг хүн амын хувь	Хувь	21.5	2023	-	-	-	15.0	5 жилд 1 удаа	ҮСХ (НҮТС)
4.	Ундны усны сайжруулсан эх үүсвэр нь сууц/хашаанд нь байдаг эх үүсвэрт нь гэдэсний савханцар (E.Coli) илрээгүй бөгөөд хэрэгтэй үед ус бэлэн байсан өрхөд амьдардаг хүн амын хувь	Хувь	30.6	2023	-	-	-	27.6	5 жилд 1 удаа	ҮСХ (НҮТС)
5.	Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг өрхөд амьдардаг хүн амын хувь (Энгийн нүхэн жорлонг сайжруулсан эх үүсвэрт оруулаагүй тооцсон)	Хувь	45.8	2023	-	-	-	50.0	5 жилд 1 удаа	ҮСХ (НҮТС)

6.	Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийн үнэлгээнд үндэслэн боловсруулсан зааврын дагуу төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн эрүүл мэндийн байгууллага	Тоо	0	2024	-	-	10	20	Жил бүр	ЭМЯ-ны ХШҮ-ний тайлан
7.	Уур амьсгалд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн эрүүл мэндийн байгууллага	Тоо	64	2024	-	13	25	70	Жил бүр	ЭМЯ-ны ХШҮ-ний тайлан
8.	Орчны эрүүл мэндийн чиглэлээр гадаадад хэвлүүлсэн өгүүлэл	Тоо	-	2024	1	2	2	2	Жил бүр	АШУҮИС НЭМҮТ
Гурав. Зохион байгуулалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт										
1.	Орчны эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан ирүүлсэн аймаг, нийслэл	Тоо	10	2024	22	22	22	22	Жилд нэг удаа	НЭМҮТ
2.	Орчны эрүүл мэндийн чиглэлээр (агаар, ус, уур амьсгалын өөрчлөлт) байгуулагдсан ажлын хэсгийн уулзалт	Тоо	10	2024	2	2	2	2	Улиралд нэг удаа	ЭМЯ
3.	Орчны эрүүл мэндийн чиглэлээр хэвлүүлсэн гарын авлага, арга зүйн зөвлөмж	Тоо	2	2024	2	2	2	2	Жилд нэг удаа	ЭМЯ
4.	Үндэсний түвшинд хэрэгжүүлсэн судалгаа, үнэлгээний тоо	Тоо	0	2024	-	1	-	1	Хоёр жилд нэг удаа	НЭМҮТ

Товчилсон үгийн жагсаалт

АБҮХ	Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо
АҮЭЗХХ	Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
АШҮҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
АЧИ	Агаарын чанарын индекс
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БЯ	Боловсролын яам
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗӨСҮТ	Зоонозын өвчин судлалын үндэсний төв
МАҮА	Монголын анагаах ухааны академи
МУ	Монгол улс
НБСШТ	Нийслэлийн бодлого судалгаа, шинжилгээний төв
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
НҮБХС	Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОУБ	Олон улсын байгууллага
ОЭМ	Орчны эрүүл мэнд
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТЦА	Тээврийн цагдаагийн алба
УБ	Улаанбаатар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХАБЭМТ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСУХАТАҮЗ	Хот суурины ус хангамж, ариутгал татуурга ашиглалтын үндэсний зохицуулагч
ХШУ	Хяналт шинжилгээ, үнэлгээ

ЦУОШГ
ШУА
ШУТИС
ЭМГ
ЭМХТ
ЭМЯ

Цаг уур орчны шинжилгээний газар
Шинжлэх ухааны академи
Шинжлэх ухаан технологийн их сургууль
Эрүүл мэндийн газар
Эрүүл мэндийн хөгжлийн төв
Эрүүл мэндийн яам